



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 2/178

Сүхбаатаг сум

Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."а", 30 дугаар зүйлийн 30.1.17, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6, 9.3.13 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хог хаягдлын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, "Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ" аяны хүрээнд аймгийн хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээ, шарилж устгах ажлыг 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсугай.

2.Аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээг сумандаа зохион байгуулж, хийж гүйцэтгэсэн ажлын зурган болон бичмэл тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 2020 оны 07 дугаар сарын 10-ны дотор ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ